



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№114 /558/

2023.07.24

Цаг үе, үйл явдал

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 342 ДУГААР АНГИД БАЙЛДААНЫ ТУГ ГАРДУУЛАН ӨГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА БОЛЛОО



аймгуудад барилга-инженерийн цэргийн ангиуд байгуулах тухай Засгийн газрын шийдвэр гарч улмаар 2021 оноос Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын зүгээс Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар хүчин чармайлт гаргаж, анги байгуулахад шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэн, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд өнөөдөр Монгол Улсын Зэвсэгт хүчин нэгэн ангиар бүл нэмж байна. Батлан хамгаалахын сайдын 2018 оны "Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах тухай" тушаалаар Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр"-ийг Сайншанд хоттой холбох 17,5 км хүнд даацын тусгай зориулалтын авто зам барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлэхээр Зэвсэгт хүчний замын ... дугаар түр ангийг байгуулсан. 2021 онд тус түр ангийн эрхийг Зэвсэгт хүчний 342 дугаар ангид шилжүүлснээр одоогийн

анги байгуулагдсан гэдгийг онцлон тэмдэглэхийг хүсч байна. Зэвсэгт хүчний 342 дугаар анги нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416 км төмөр зам, Зүүнбаян-Ханги чиглэлийн 204 км төмөр зам, Богдхан төмөр зам, Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөл, шинэчлэлийн бүтээн байгуулалтын ажилд үүрэг гүйцэтгэж, улс эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлсээр байна. Өнөөдөр, тус ангийн гадна хашаа, шалган нэвтрүүлэх хоёр байр, цахилгаан шугам сүлжээ бүрэн ашиглалтад орж, 2023 онд Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар цэргийн байр, гал тогоо, уурын зуух, дулааны шугам сүлжээ, жагсаалын талбайг ашиглалтад оруулахаар барилга угсралтын ажил ид өрнөж байна. Байлдааны тугаа хүлээн авч байгаа Зэвсэгт хүчний 342 дугаар ангийн бие бүрэлдэхүүн Та бүхэн Монгол цэргийн сүлд хийморь, нэр төрийг эрхэмлэн дээдлэж, ард түмэндээ өргөсөн тангарагаа чанд сахиж, эх орныхоо

тусгаар тогтнол, улсыг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтын ажилд бие сэтгэл, оюун ухаан, мэдлэг чадвараа бүрэн зориулж ажиллана гэдэгт Батлан хамгаалахын сайдын хувьд итгэлтэй байна" хэмээн онцлов. Тус анги байгуулагдсанаар улс эх орны стратегийн томоохон бүтээн байгуулалтын ажилд оролцохоос гадна орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж, ажлын байр бий болох боломж бүрдэх юм. Өнөөдрийн байдлаар тус ангийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил эд өрнөж байна. Улмаар ангийн үйл ажиллагаа жигдэрч, бүрэн ашиглалтад орсон дараа буюу намраас хугацаат цэргийн алба хаагчдаа цэргийн бэлтгэл үүрэгтнээр бэлтгэх ажилдаа орох юм. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Байлдааны тугаа гардсан ангийн бие бүрэлдэхүүнд баяр хүргэж, амжилт хүсээд ачааны портер автомашин, сургалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх олон үйлдэлт ухаалаг дэлгэц, тавилга хэрэгслийг гардуулсан юм.

Архангай аймагт Монгол Улсын Зэвсэгт хүчний БИЦУГ-ын харьяа 342 дугаар анги үйл ажиллагаагаа эхлүүлсэн билээ. Өнөөдөр тус ангийн бие бүрэлдэхүүн Зэвсэгт хүчний анги, байгууллагын сүлд хийморь, цэргийн алба хаагчдын сүсэглэн дээдлэх оройн дээд шүтээн болсон Байлдааны тугаа гардаж авлаа. Энэхүү үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-

ын дарга хошууч генерал С.Ганбямба болон Архангай аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид тэргүүтэй албаныхан оролцсон юм. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Зэвсэгт хүчний 342 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Д.Зоригсайханд Байлдааны тугийг гардуулсаны дараа тус ангийн бие бүрэлдэхүүнд хандан хэлсэн үгэндээ, "Монгол Улсын Засгийн газрын 2015 оны тогтоолоор Архангай, Говь-Алтай



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	🌧️ 13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 37	🌧️ 24

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,428	3,436
EUR 🇪🇺	3,780	3,808
CNY 🇨🇳	478	483
RUB 🇷🇺	38.05	38.30
JPY 🇯🇵	23.50	25.10
KRW 🇰🇷	2.64	2.68

### ЗУРХАЙ



2023.07.24 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 6

**ЗУНЫ АДАГ ШАРАГЧИН ХОНЬ САР**  
**ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ХОНЬ ӨДӨР**

Үс засуулбал:

Өнгө зүс сайжирна  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
05.14-20.43  
Барилдлага:  
Үл зохилдох  
Шүтэн барилдлага:  
Мунхрахуй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, сүм, суварга барих, хүүрийн газар эргэх, чуулан үймэхэд сайн. Нүд татваас эцэг эхэд аюул болох, баруун чих хангинавал эхнэртэй учрах, зүүн нь бол идээ ундаа олодох, нохой уливал гэнэт зочид ирэх болой. Энэ өдөр өндөр язгуурт хүний хэл ам болох, тагнай загатнавал их хүн ирэх, бие татвал хэрүүл тэмцэл болох, хөл татвал сайн.

## ХӨВСГӨЛ НУУРЫН ГҮНД 28 ЖИЛ БОЛСОН ШАТАХУУН ТЭЭВРИЙН ЧИРГҮҮЛТЭЙ "ЗИЛ-130" АВТОМАШИНЫГ ТАТАН ГАРГАЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, нуурын ёроолын аюултай хог хаягдлыг цэвэрлэх, бохирдлыг бууруулах зорилгоор живсэн тээврийн хэрэгслийн байршлыг илрүүлж тогтоох, татан гаргах ажиллагаа Хөвсгөл нуурын "Марааны булан"-д үргэлжилж байна.

Тус ажиллагаанд ЗХЖШ-ын

Ажиллагааны удирдлагын газрын Инженерийн дарга хурандаа Ц.Ганхөлөгөөр ахлуулсан Зэвсэгт хүчний 186, 234 дүгээр ангийн 30 цэргийн алба хаагч Хөвсгөл аймагт 6 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн ажиллаж байгаа бөгөөд энэ удаа онцгой байдлын байгууллагын аврагчид, ШУТИС-ийн эрдэмтэн багш нартай хамтран Хөвсгөл нуурын Марааны булангийн эргээс 2500 орчим метр зайтай, 128 метрийн

гүнд 1995 онд живсэн шатахуун тээврийн 58-12ХӨ улсын дугаартай (Ч47-13) "ЗИЛ-130" загварын 17.8 тонн жинтэй чиргүүлтэй автомашиныг тусгай зориулалтын техник хэрэгсэл ашиглан татан гаргалаа.

Татан гаргасан шатахуун тээврийн чиргүүлтэй автомашинаас нийтдээ 10 тонн шатахуун, тос, тосолгооны материал гарсан бөгөөд тус бохирдлыг аюулгүй болгож, нуурын бохирдлыг бууруулахад бодит хувь нэмэр орууллаа.



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 691,200,896

Эдгэрсэн

Нийт: 664,110,023

Нас барсан

Нийт: 6,903,890

Цахим шууданд

# ТӨВ АЙМАГТ ЦЭРГИЙН ЁСЛОЛЫН ЖАГСААЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



аймгийн Алтанбулаг сумын харьяат, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн мотобуудлагын батальоны ахлагч, тэргүүн ахлагч Б.Алтангэрэл Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ой, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн 100 жилийн ойг тус тус тохиолдуулан өөрийн санаачилгаар 05 дугаар сарын 25-ны өдрөөс эхлүүлсэн алсын зайн гүйлтээ 62 хоногийн хугацаанд 2100 км замыг туулж, цэрэг хүний эр зориг, ур чадвар, тэсвэр тэвчээрийг олон нийтэд сурталчлан таниулсанд талархал илэрхийлж, хүндэтгэл үзүүллээ.

Мөн энэ өдөр Богдхан уулын аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ой болон Төв аймгийн баяр наадмыг тохиолдуулан Ардын Засгийн газрын анхны Ерөнхий сайд, Төр нийгмийн нэрт зүтгэлтэн Догсомын Бодоогийн хөшөөнд цэцэг өргөлөө.

Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баярт зориулсан цэргийн ёслолын жагсаал Зуунмод сумын төв талбайд зохион байгуулагдлаа. Ёслолын жагсаалд Батлан хамгаалахын сайд асан, УИХ-ын гишүүн Н.Энхболд, УИХ-ын гишүүн Д.Батжаргал, Төв аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, Засаг дарга Д.Мөнхбаатар, ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах, Зэвсэгт хүчний

Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал, "Монгол генерал" ТББ-ын тэргүүн бэлтгэлд байгаа хошууч генерал С.Баасанхүү тэргүүтэй Зэвсэгт хүчний генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагч, ахмад дайчид, Төв аймгийн ард иргэд оролцлоо.

Төв аймаг дахь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын ёслолын жагсаалын үеэр Төв



## “ТУНГАЛАГ МЭЛМИЙ–2023” САЙН ДУРЫН ХҮМҮҮНЛЭГИЙН АЖИЛЛАГАА ЭХЭЛЛЭЭ



Энэхүү сайн дурын хүмүүнлэгийн ажиллагааны үргэлжлэл болох “Тунгалаг мэлмий-2023” арга хэмжээ өнөөдөр эхэллээ. 7-р сарын 21-ээс 28-нд Улаанбаатар хот, Орхон, Хөвсгөл аймгуудад явагдах уг ажиллагааны хүрээнд БНСУ-ын Нүдний шилний нийгэмлэгийн сайн дурын ажилтнууд Монгол Улсын төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмадуудад үнэ төлбөргүй нүдний харааны үзлэг хийж, нүдний шил тааруулж өгөх юм.

Нүдний харааг авто рефрактоороор шалгаж, тухайн хүний нүдний хараанд тохирсон шилийг газар дээр тааруулан олгох бөгөөд тохирсон шил бэлэн байхгүй тохиолдолд нүдний шилийг БНСУ-д захиалан хийлгэж, эргэж хүргүүлэх арга хэмжээг авч ажиллах юм.

### МОНГОЛ ЦЭРГИЙН НЭГДСЭН ХОЛБОО



Монгол цэргийн нэгдсэн холбоо, БНСУ-ын Нүдний шилний нийгэмлэгтэй хамтран “Тунгалаг мэлмий” сайн дурын хүмүүнлэгийн үйл ажиллагааг 2022 оны 9 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Уг арга хэмжээнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын 3000 гаруй ажилтан албан хаагч, ахмадууд, тэдний гэр бүлийн гишүүд хамрагдаж, нүдний хараагаа үнэ төлбөргүй оношлуулж, харааны болон нарны хамгаалалтын шил үнэ төлбөргүй хүлээн авсан юм.

### Гэрэл зураг түүх өгүүлнэ



“ОЮУТАН ЦЭРЭГ-2023”

## ХУРАНДАА ГЕНЕРАЛ Ж.ЁНДОН АГСНЫ ХӨШӨӨНИЙ НЭЭЛТ БОЛЛОО



Цэргийн дуу бүжгийн мэндэлсний 100 жилийн ойд зориулан Эрдмийн чуулгын хамт олон бүтээсэн хөшөөний нээлтийн арга хэмжээ, Мөнххаан сумын 100 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээнд оролцон нутгийн ард иргэд, хүндэт генерал Жамсрангийн Ёндон агсны



## НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА



Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2023-2024 онд үүрэг гүйцэтгэх штабын ажилтан (офицер), цэргийн мэргэжилтний (цэргийн ажиглагч, холбогч офицер) сонгон шалгаруулалтыг 2023 оны 09 дүгээр сарын 04-нөөс 09 дүгээр сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд батлагдсан “ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ”-тай танилцаж, НҮБ-ын штабын ажилтан, цэргийн мэргэжилтэнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ.

Үүнд: 1.

Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;

2. Ажил байдлын тодорхойлолт;
3. Жолооны үнэмлэхийн хуулбар;
4. Гадаад паспортын хуулбар;
5. Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар;
6. Сүүлийн 3 сарын дотор авхуулсан 4х6 хэмжээтэй цээж зураг 2 хувь;
7. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт
8. Товч судалгаа (доорх хүснэгтийн дагуу бөглөх);

Анги	Албан тушаал	Цол	Өвөг зэр	Нас, хүйс	Боловсрол, цэргийн мэргэжил, дамжаа төгссөн байдал	Анги, байгууллагад ажилласан байдал	Одоогийн албан тушаалд томилогдсон өгнөө	ЗДА-нд үүрэг гүйцэтгэсэн байдал	Англи хэлний түвшин тогтоох шалгалтын өгнөө (Хамгийн сүүлд өгсөн ALCPRT, ECLT, TOEFL, IELTS)
------	--------------	-----	----------	-----------	--	-------------------------------------	--	---------------------------------	--

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтэс psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3679, 99732447, 88689855, 70152660/-тай холбогдож тодруулна уу. “ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ”-тай ЗХЖШ-ын цахим хуудасны эрх зүйн булан буюу <https://gsmaf.gov.mn/gsmaf/cat/60> холбоосоор орж танилцана уу.

### ЗХЖШ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ, ЦЭРГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс: 10018

Цахим шуудан:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)